



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 12 сарын 02 өдөр

Дугаар

А/1401

Улаанбаатар хот

“Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд мал орж ирэхээс урьдчилан сэргийлэх” дэд ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн хил хязгаарыг тогтоож журам батлах тухай” 09 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Журмын хэрэгжилтийг хангуулах тухай” А/1589 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, мал амьтны гаралтай гоц халдварт өвчин дамжин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс мал гаргах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий байнгын ажиллагаатай дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Дүүргийн нутаг дэвсгэрт хариулгагүй орж ирсэн мал, мал бүхий иргэдийг хориглосон бүсээс гаргах арга хэмжээнд шаардагдах зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т зөвшөөрсүгэй.

3. Хориглосон бүсэд хариулгагүй орж ирсэн малын эзэн холбогдогчийг тогтоож, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг дүүргийн Цагдаагийн газар (Ц.Түвшинжаргал)-д үүрэг болгосугай.

4. Дэд ажлын хэсгийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг дүүргийн менежер (Д.Уянга)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Бямбагэрэл)-д тус тус даалгасугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2025 оны “Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд мал орж ирэхээс урьдчилан сэргийлэх дэд ажлын хэсэг байгуулах тухай” А/37 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2025
оны ...12... дугаар сарын ...02... өдрийн
...1/2021... дугаар захирамжийн хавсралт



ДЭД АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга

Дүүргийн менежер

Гишүүд

Нийслэлийн Байгаль орчны газрын
дарга (Зөвшилцсөнөөр)

Засаг даргын Тамгын газрын Санхүү,
төрийн сангийн хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Хотын
стандарт, тохижилт нийтийн аж ахуйн
хэлтсийн дарга

Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн
дарга

Дүүргийн Цагдаагийн газрын дарга

Дүүргийн Цагдаагийн газрын 2 дугаар
хэлтсийн Зуслан дахь Цагдаагийн
тасгийн дарга

Дүүргийн Мал эмнэлэгийн үйлчилгээний
байгууллага

Дүүргийн 7-оос 24 дүгээр хорооны Засаг
дарга

Дүүргийн Теле камерын хяналтын дэд
төв ОНӨТҮГ-ын дарга

Нарийн бичгийн
дарга

Засаг даргын Тамгын газрын Хүнс,
худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга